



“МИН ТРАНС” ХХК-д

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДУГНЭЛТ

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, II хороо, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: 70112333, Факс: (976-11) 31-23-15  
E-mail: [info@mrt.gov.mn](mailto:info@mrt.gov.mn), <http://www.mrt.gov.mn>

2016.06.08

№ 38-04-002/014

Стандартын шаардлага хангасан тухай

Зам тээврийн яамны 2016 онд хийх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, “АТҮТ” ТӨҮГ-тай байгуулсан гэрээнд тусгагдсны дагуу “стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх” ажлын хүрээнд Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Билгүүний баталсан 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 38-07-003/014 бүхий дугаар удирдамжийн дагуу танай компанийн байцуулан тээвэрлэгч жолооч, тээврийн хэрэгслүүдэд Авто тээврийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын шаардлага хэрхэн хангасан байдалд хяналт шалгалт хийлээ.

Тодорхойлох нь:

Шалгалтад тус байгууллагын Солонгос улсад үйлдвэрлэсэн HYUNDAI AERO, KIA GRANBURD маркийн 1131 УБН, 0353 УНР, 5977 УБҮ, 5465 УБИ, 6838 УБР, 7823 УББ, 2823 УНХ, 5977 УБҮ, 6891 УНТ, 7910 УББ, 8727 УБМ, 6008 УБА, 9638 УБӨ, 8068 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгсэлүүд, тээвэрлэгч жолооч Г.Түвшинзаяа, Г.Отгонбаатар, Б.Пүрэвдорж, Э.Анхбаяр, Б.Жавхлан, Х.Мөнхжаргал, О.Эрдэнэцогт, А.Ганхуяг, Г.Батбаатар, Х.Сайнтөмөр, О.Пүрэвжав, Э.Чулуун, Б.Даваажаргал нар хамрагдсан.

1. Тээврийн хэрэгсэл дотор замналын нэр, эцсийн ба дундын зогсоолуудын нэр, ачааны жин, овор хэмжээний талаарх санамжийг нийтэд мэдэгдэхээр бичиж байрлуулсан байгаа нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 5.6, 5.7 дахь заалтуудыг;

2. Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг, заалт, бусад санамжууд/суудлын бүс, үнэ хөлс, цагийн хуваарь/-ыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 5.9 дэх заалтыг;

3. Жолооч нарыг эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт жил бүр хамруулж, ажлын хувцасаар хангаж, нэрийн хуудсыг тээврийн хэрэгслийн дотор байрлуулсан нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 6.7, 6.8 дахь заалтуудыг тус тус хангасан байна.

Дүгнэлт

1. Танай компанийн тээврийн хэрэгслүүд, тээвэрлэгч жолооч нар нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5012:2011 улсын стандартын 7.1, 8.2.1 дэх заалтыг бүрэн хангасан;

2. Цаашид тээврийн хэрэгслийн ялгах туузыг шинэчлэх, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS5012:2011 улсын стандартын 7.1-д заасны дагуу зорчигчдын ая тухтай, аюул осолгүй зорчих, аялах нөхцөл бүрдсэн, техникийн хувьд бүрэн бүтэн “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий - шаардлага” MNS4598:2011 улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэх шаардлагатай гэж дүгнэлээ.

АВТО ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Э.ОЮУНТУНГАЛАГ

Хүлээн авсан:

“МИН ТРАНС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

М.БАЛЖИННЯМБАА



8 127